



**НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А19

Улаанбаатар хот


Тогтоолын хавсралтад өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус 19 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны А/39 тоот тогтоолын 3 дугаар хавсралтын 2.1-д заасан төсөл хөтөлбөр арга хэмжээний Багахангай дүүргийн “1 дүгээр хорооны 2,3,4,5,6 дугаар байр, 2 дугаар хорооны 3,4,5,6,7,8,9,12,13,14,16 дугаар орон сууцны байрнуудын орцны засварын ажил” гэснийг “1 дүгээр хорооны 2,3,4,5,6 дугаар байрнуудын орцны засварын ажил гэж өөрчилсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд даалгасугай.

ДАРГА



Ф.МӨНХГЭРЭЛ

Нийслэлийн Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн
19 дүгээр тогтоолын хавсралт

Нийслэлийн Багахангай дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн
хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга
хэмжээний жагсаалт

(мянган төгрөгөөр)

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил		Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	2023 онд санхүүжих дүн
	1.Шилжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээ	I	-	-	-
	2.Шинээр эхлэх хөрөнгө оруулалт	II		306,010.7	306,010.7
2.1	Багахангай дүүргийн нэгдүгээр хорооны 2,3,4,5,6 дугаар байрнуудын орцны засварын ажил	1	2023-2023	301,010.7	301,010.7
2.2	Малын худаг засварлах ажил	2	2023-2023	5,000.0	5,000.0
	Нийт			306,010.7	306,010.7